

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО
ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулсан байдал, төлөвлөлт нь хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн түвшингээр тодорхойлж, зорилтот түвшинг бүрэн хангаж үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гарган удирдлага болон дээд шатны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээний арга зүй.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 03 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ыг удирдлага болов.

Гурав. Хяналт-шинжилгээний талаар

Сэлэнгэ аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүтэн жилийн хүрээнд 6 зорилтын 49 арга хэмжээ төлөвлөснөөс жилийн эцсийн тайланд үндсэн 6 зорилтын 49 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ хийж үнэлэв.

№	Зорилт, арга хэмжээ	САБТСГ Гүйцэтгэл ийн хувь	БТСУХ Үнэлгээ
Зорилго-1 Идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлэх			
Зорилт-1.1 Ард иргэд, хүүхэд, залуучуудыг биеийн тамирын арга хэмжээгээр дамжуулан бялдаржуулах, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт сургах насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх			
1	Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, дүн мэдээг нэгтгэх	100	70
2	"Бие бялдрын түвшин тогтоох сорилын төв"-д иргэдээс насны ангиллаар сорил авах, үр дүнг тооцох, судалгаа хийх арга аргачлалыг боловсруулж гаргах, үйлчлүүлсэн иргэдийг фитнес, иог, усан сэлэлт гэх мэт спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, үйл ажиллагааг төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх	100	80
3	Арга хэмжээ 1.1.3 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн"-ийг улсын хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллолт, хорт зуршил, дасгал хөдөлгөөн, биеийн тамир, спортын арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай	100	50

	хамтран өсвөр, залуучууд, насанд хүрэгчид, ахмад, гэр бүл, ахмадын дунд зохион байгуулах		
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах	100	80
5	Бүх нийтийг хамарсан алхалт, гүйлт, дугуй, иог, шугаман бүжиг, фитнес, гэх мэт спортын төрлүүдээр биеийн тамирын арга хэмжээг "Өөртөө Цаг гаргая" уриан дор төрийн болон төрийн бус байгууллагуудтай улирал бүр иргэдийн дунд хамтран зохион байгуулах	100	100
6	Иргэдийн дунд Өвөл цагийн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран насны ангиллаар зохион байгуулах	100	100
7	Ерөнхий боловсролын сургууль, биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа клубийн үйл ажиллагааг дэмжих, биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж хамтарч ажиллах	100	100
8	Ахмадын нас биеийн онцлогт тохирсон биеийн тамирын арга хэмжээг улирал бүр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягт уриалж дэмжлэг үзүүлэх	100	100
9	Биеийн тамир, спортын салбарын албан хаагчдын дунд туршлага судлах, биеийн тамир, спортын тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах	100	100
10	Эрэгтэйчүүдийн сонирхлоор нэгдсэн клуб, спортын төрлөөр дамжуулан эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах, зөвлөгөө өгөх, зөв үлгэр дуурайлал үзүүлж буй бүлэг, клубийг дэмжих, сурталчлах	-	-
11	Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхыг дээшлүүлэх, төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтэй иргэдэд зориулсан бүсийн сургалтыг зохион байгуулах	-	-
12	Иргэд, ажилтан албан хаагчдыг идэвхтэй хөдөлгөөнд хамруулах, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл бий болгосон аж ахуй нэгж байгууллагыг "Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага"-аар шалгаруулах, сурталчлах	-	-
13	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдын дунд биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	-	-
14	Биеийн тамир, спортын салбарын улсын III зөвлөгөөнд оролцох	100	100
15	Сумдын арга зүйчдийг мэргэжлийн зэрэг олгох сургалтад хамруулах	-	-
Зорилго-2 "Спортлог Сэлэнгэчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх			
Зорилт-2.1 "Спортлог" Сэлэнгэчүүд хөтөлбөрийн хүрээнд аймгийн иргэдийн дунд насны ангиллаар, биеийн тамирын арга хэмжээг хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах			
16	"Сэлэнгэ Марафон" гүйлтийн арга хэмжээг зохион байгуулах	100	100
17	Өсвөр үеийнхний дунд Монголын уламжлалт тоглоом, наадгайн арга хэмжээг зохион байгуулах	100	100

18	Хүн амын амьдралын хэв маяг идэвхтэй хөдөлгөөний мэдлэг, хандлага, дадалтай иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор "Иргэдийн спортын их наадам"-ыг 17 сумын иргэдийн дунд 4 үе шаттай зохион байгуулах	100	100
19	"Хаврын баяр-2025" Биеийн тамирын арга хэмжээг 17 сумын иргэдийн дунд спортын 7 төрлөөр зохион байгуулах	100	100
Зорилго-3 Спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх			
Зорилт-3.1 Үндэсний спортыг хөгжүүлж, уралдаан тэмцээний тогтолцоог боловсронгуй болгож, тамирчдын ур чадварыг ахиулж улс тив дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг бэлтгэн чадваржуулах			
20	Сэлэнгэ бага олимп Хүүхдийн спортын наадмыг зохион байгуулж, спортын зарим төрлүүдээр улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулах	100	100
21	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн спортыг дэмжиж мэргэжлийн түвшинд өрсөлдөх тамирчдыг нэмэгдүүлж, амжилтыг үнэлэх.	100	100
22	Өвлийн болон багийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ.	100	90
23	Шигшээ багийн үйл ажиллагааг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх	100	100
24	Спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандартуудыг сайжруулан аймгийн хэмжээнд спортын төрлийн стандартын техник хэрэгслийг нэмэгдүүлэн сурталчилах ажлыг зохион байгуулах	100	100
25	Ахмадуудын дунд спортын төрлөөр арга хэмжээг зохион байгуулах	100	100
26	Шинээр хөгжиж буй төрлүүдийг дэмжин мэргэжил арга зүйн удирдлагааг хангах	100	100
27	Усан спортоор хүүхэд, залуучууд, иргэдийг хичээллэх боломжоор ханган усан сэлэлтийн тэмцээнийг зохион байгуулах	100	100
28	Тамирчин дасгалжуулагчдын ажлын бүтээмжийг үнэлэх урамшуулах хөшүүргийг бий болгох	100	100
Зорилго-4 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах			
Зорилт-4.1 Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох			
29	Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төсөл боловсруулж хүргүүлэх	100	50
30	Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах	100	100
Зорилт-4.2 Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх			
31	Байгууллагын албан хаагчдын 2025 оны сургалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	100	100
32	Байгууллагын албан хаагчдын 2025 оны нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах	100	100
Зорилт-4.3 Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх			

33	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, үйл ажиллагаа зохион байгуулах, тайлагнах	100	100
34	Хүүхдийн эрхийг хангах талаар үйл ажиллагаа зохион байгуулах, тайлагнах	100	90
35	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах	90	80
36	Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж илрүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах	100	100
37	Тэмдэглэлт өдрүүдэд Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх	100	100
38	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээн дэх арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	100	100
39	Албан тушаалтны ХАСХОМ, ХАСУМ-ийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах	100	100
40	Арга хэмжээ 4.3.3. Байгууллагын ёс зүйн дэд хорооны жилийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллах	100	90
Зорилт-4.4 Салбарын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх			
41	Салбарын төрийн цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	100	100
42	Салбарын хэмжээнд зохион байгуулагдах спортын наадмын мэдээллийн сан бүрдүүлэх	100	100
Зорилго-5 Төсөв, санхүүг оновчтой төлөвлөх			
Зорилт-5.1 Төсөв, санхүүг оновчтой төлөвлөх, санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах			
43	Төсөв, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах	100	100
44	Байгууллагын 2025 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохицуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах	100	100
45	Төсвийг эдийн засгийн ангилал хөтөлбөр зориулалтын дагуу байгууллага нэгжээр хуваарилах	100	100
Зорилго-6 Хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, эрсдлийн удирдлагаар хангах			
Зорилт-6.1 Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх			
46	Биеийн тамир спортын газарт сургалтын танхимын үйл ажиллагааг сайжруулан сургалтыг зохион байгуулах	100	100
47	Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх	100	100
48	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх,	100	100
49	Салбарын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шинжилгээг чанаржуулан, мэргэжлийн байгууллагаар аудит, хяналт шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах	100	100
	Дундаж хувь	99,4	95,0

100% гүйцэтгэлтэй-35 арга хэмжээ, 90 %-ийн хэрэгжилттэй-3 арга хэмжээ, 80%-ийн хэрэгжилттэй-3 арга хэмжээ, 70%-ийн хэрэгжилттэй -1 арга хэмжээ, 50%-ийн хэрэгжилттэй -2 арга хэмжээ, хэрэгжээгүй- 5 арга хэмжээ

Дөрөв.Зорилт арга хэмжээг үнэлгээний аргачлалаар харуулбал:

№	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээний хэрэгжилт		
		"Бүрэн хангалттай"	"Хангалттай"	"Хангалтгүй"
		85-100 хувь	70-85 хүртэл хувь	0-70,хүртэл хувь
1	2	3	4	5
1	Зорилт-1.1 Ард иргэд, хүүхэд, залуучуудыг биеийн тамирын арга хэмжээгээр дамжуулан бялдаржуулах, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт сургах насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх	6	3	6
2	Зорилт-2.1 "Спортлог" Сэлэнгэчүүд хөтөлбөрийн хүрээнд аймгийн иргэдийн дунд насны ангиллаар, биеийн тамирын арга хэмжээг хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах	4		
3	Зорилт-3.1 Үндэсний спортыг хөгжүүлж, уралдаан тэмцээний тогтолцоог боловсрснгуй болгож, тамирчдын ур чадварыг ахиулж улс тив дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг бэлтгэн чадваржуулах	9	1	1
4	Зорилго-4 Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах	12	1	
5	Зорилт-5.1 Төсөв, санхүүг оновчтой төлөвлөх, санхүүгийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах	3		
6	Зорилт-6.1 Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх	4		
Нийт		37	5	7
Бүгд		49 арга хэмжээ		

Үр дүн. Төлөвлөсөн 49 арга хэмжээнээс 2025 оны жилийн эцсийн байдлаар 37 арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан гүйцэтгэлтэй 85-100%-ийн гүйцэтгэлтэй, 5 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт хариуцлагыг сайжруулах шаардлагатай буюу 70-85%-ийн гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилт хангалтгүй 7 арга хэмжээ байна. Үүний 5 арга хэмжээ нь Төсвийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой төсөв татагдсанаас хэрэгжүүлээгүй байна.

Арга хэмжээ 4.1.1 Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн төсөл боловсруулж хүргүүлэх гэсэн арга хэмжээ тайлагналт хангалтгүй шалгуур болон зорилтот түвшинтэй уялдаагүй тул хэрэгжилт хангалтгүй гэж үнэлсэн.

Арга хэмжээ 1.1.3 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн”-ийг улсын хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллолт, хорт зуршил, дасгал хөдөлгөөн, биеийн тамир, спортын арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран өсвөр, залуучууд, насанд хүрэгчид, ахмад, гэр бүл, ахмадын дунд зохион байгуулах
Шалгуур үзүүлэлтээ 6600 хүнийг хамруулахаар төлөвлөсөн хэдий ч төсөв татагдсанаас хэрэгжилт хангалтгүй, зорилтот түвшинд хүрээгүй байна.

Тус аймгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан нь Монгол Улсын засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журам, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тогтоолоор батлагдсан загвар маягаар ирүүлээгүй нь төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв тайлагнах, үр дүнтэй бодит тайлагнахад нөлөөж байна.

Дүгнэлт:

2025 оны жилийн эцсийн байдлаар Сэлэнгэ аймгийн Биеийн тамир спортын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 95,0%, “бүрэн хангалттай” гэсэн үнэлгээний хязгаарт багтаж байна.

Төсөв татагдсанаас шалтгаалан хэрэгжээгүй 5 арга хэмжээг үнэлгээнээс хасаж тооцов.

Зөвлөмж:

Төлөвлөлтөд анхаарах асуудал:

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт загвараар боловсруулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 07 дугаар хавсралтад туссан загвараар тайлагнаж хэвших

2. Төлөвлөлтийн шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц, тодорхой, бодит үр дүнд чиглэсэн байдлаар зөв оновчтой тодорхойлох;

3. Төлөвлөлтөд тусгагдсан арга хэмжээний төсөв, санхүүг зөв зохистой, үр дүнтэй зарцуулахад чиглүүлж, эрсдлийг тооцоолж төлөвлөх;

4. Байгууллагын гүйцэтгэлийн тайланд Хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын хүрээнд бодитой, хариуцсан албан хаагчийг чадавхжуулах;

5. Гүйцэтгэлийн тайланд арга хэмжээ бүрт гарсан үр дүн, үр нөлөө, зарцуулсан төсвийг тусган 2000 тэмдэгтэд багтаан товч дүгнэлттэй тайлагнаж хэвшихийг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ

АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.БИЛЭГТ

Н.БАТСҮХ

Н.ДҮНЖИЙМАА